



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/255

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Монголын Улсын Ерөнхийлөгчийн 25 дугаар зарлиг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 25 дугаар зарлигаар жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийг “Үндэсний бичиг үсгийн баяр” болгон орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх болсонтой холбогдуулан “Миний монгол бичиг-2022” гар бичлэгийн үзэсгэлэн, “Байгууллагаараа монгол бичигтэн” аян зэрэг арга хэмжээнүүдэд шаардагдах зардалд 4,350,000 (дөрвөн сая гурван зуун тавин мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэх зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиглахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231916133

Аймаг
 А/255
 Аймгийн Засаг даргын 2022 оны
 дугаар сарын 06 өдрийн
 дугаар захирамжийн хавсралт

Зарцуулах хөрөнгийн тооцоо

Үндэсний бичиг үсгийн баяр тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төсөв			
1	"Байгууллагаараа монгол бичигтэн"	2,700,000	7 байр
2	Миний монгол бичиг-2022 үзэсгэлэн	1,625,000	5 байр
Нийт		4325000	

Байгууллагаараа Монгол бичигтэн				
№	Зарцуулалт	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Өргөмжлөл	100,000	7	700,000
2	Мөнгөн шагнал 1-р байр	500,000	1	500,000
3	Мөнгөн шагнал 2-р байр	400,000	1	400,000
4	Мөнгөн шагнал 3-р байр	250,000	3	750,000
5	Мөнгөн шагнал тусгай байр	100,000	1	100,000
6	Бэрх тосгоны эх хэлний салбар зөвлөл	100,000	1	100,000
7	Зохион байгуулалт, бичиг хэргийн зардал	150,000	1	150,000
Нийт				2,700,000

"Миний Монгол бичиг" багийн олон бичвэрийн үзэсгэлэн				
№	Зарцуулалт	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Өргөмжлөл	25,000	5	125,000
2	Мөнгөн шагнал 1-р байр	500,000	1	500,000
3	Мөнгөн шагнал 2-р байр	300,000	2	600,000
4	Мөнгөн шагнал 3-р байр	200,000	2	400,000
Нийт				1,625,000